

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

Гагнуурын зориулалттай цахилгаан үүсгүүр (380/220 В), Өнгөт металлын аргон гагнуурын аппарат дагалдах хэрэгслийн хамт, Цахилгаан үүсгүүр (мотор -220 В), Цахилгаан гагнуурын аппарат нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг

Тендер шалгаруулалтын дугаар:

ХАН№19/03

Хаяг:

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ний конторын байр

Утас:

99020551

Факс:

70210167

ХА.№19/03 тоот тендерийн урилга

Гагнуурын зориулалттай цахилгаан үүсгүүр (380/220 В), Өнгөт металлын аргон гагнуурын аппарат дагалдах хэрэгслийн хамт, Цахилгаан үүсгүүр (мотор -220 В), Цахилгаан гагнуурын аппарат нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр илгээж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтаас /Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/ татаж үзнэ үү.

Хаяг :

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний
конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99020551

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг цахимаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Санал болгож буй материалыг үнийн саналын маягтын дагуу ирүүлэх;
 - (б) Нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) ТООЗ 1.1 дэх заалтын дагуу бусад материалыг бэлтгэж ирүүлэх.
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар, НӨАТ биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх 4. 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх. 5. Сүүлийн хоёр /2017-2018 он/ жилийн борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/ 6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн ямар нэгэн зарга маргааны талаарх тодорхойлолт. /Шүүхийн төрөлжсөн архив, ШШГЕГ-аас тус тус ирүүлэх/ 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын тендерийн лавлагааг үндэслэнэ/ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолтыг ирүүлэх /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/ 9. Тендерт оролцогч нь ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 10. Нийлүүлэх хугацаа нь гэрээ байгуулсанаас хойш ажлын 15 хоногоос ихгүй, хүргэх газар Багануур дүүргийн үйлдвэрийн хэсгийн “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад 11. Ижил төстэй ажлын жагсаалт гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын өртөг, хугацаа байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх. /2016-2018 онуудын аль нэгэнд/ Манай компанид ижил төстэй бараа материал нийлүүлэх гэрээ хийж хамтран ажиллаж байсан бол энэ тухай тодорхойлолт шаардлагагүй. 12. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Нээлтийг 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 15 цаг 30 минутаас цахим системээр нээнэ.</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99020551</p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна:</p> <p>ХАН№19/03 “Гагнуурын зориулалттай цахилгаан үүсгүүр (380/220 В), Өнгөт металлын аргон гагнуурын аппарат дагалдах хэрэгслийн хамт, Цахилгаан үүсгүүр (мотор -220 В), Цахилгаан гагнуурын аппарат нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг” Багцтай эсэх: Үгүй</p>

Гурав. МАТЕРИАЛЫН ТОО ХЭМЖЭЭ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тодорхойлолт
1	Гагнуурын зориулалттай цахилгаан үүсгүүр (220 В, 5кВт)	ш	2	Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу
2	Өнгөт металлын аргон гагнуурын аппарат, дагалдах хэрэгслийн хамт	ком	1	
3	Цахилгаан үүсгүүр (мотор - 220 В, 5.5 кВт)	ш	1	
4	Цахилгаан гагнуурын аппарат /Инвертер технологи-IGBT/	ш	1	

МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ГАГНУУРЫН ЗОРИУЛАЛТТАЙ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
ХӨДӨЛГҮҮР		
1	Хөдөлгүүр төрөл	Дизель
2	Хөдөлгүүрийн чадал (kW)	7.5 багагүй
3	Асаалтын систем	Статёр
4	Түлшний зарцуулалт (л/цаг)	2 ихгүй
5	Түлшний сав (л)	20 ихгүй
6	Эргэлт (эрг/мин)	1500 ихгүй
ГАГНУУР		
7	Гаралтын гүйдэл DC (A)	10-120
8	Хүчдэл (В)	30.4 ихгүй
9	Электродны диаметр (мм)	2-6
10	Тасралтгүй ажиллах хугацаа	100%
ГЕНЕРАТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ		
11	Гаралтын чадал (кВт)	5
12	Гаралтын хүчдэл (В)	380/220
13	Давтамж (Гц)	50
14	Фаз	3
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА		
Дууны түвшин (mdB)		63
Ачааллаас нь хамааруулан хөдөлгүүрийн чадлыг тохируулах боломжтой		
Гадаа ажиллуулах боломжтой, зөөврийн, дагалдах хэрэгслийн хамт		
Гагнуур хийх явцад давхар цахилгаан үүсгүүрийг ашиглах боломжтой, дуу намсагчтай битүү загварынх байх		

ӨНГӨТ МЕТАЛЛЫН АРГОН ГАГНУУРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Гаралтын гүйдэл (A)	10-180
2	Оролтын тэжээл	220В /50 Гц /1 фаз

3	Оролтын чадал (кВА)	5
4	Утасны диаметр (мм)	1.6-4.0
5	Хүчдэл (В)	65
6	Үйлдэл	DC/AC stick, DC/AC TIG
7	Овор хэмжээ (мм)	405*170*310 ихгүй
8	Жин	24.7 кг
9	Тасралтгүй ажиллах хугацаа	35%

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Зөөврийн зориулалттай байх , дагалдах хэрэгслийн хамт /Баллон, редуктор/
Инвертерийн технологиор үйлдвэрлэсэн байх
АС/DC TIG хөнгөнцагаан цагаан материал гагнадаг байх
TIG/MMA 2 төрлийн функцтэй байх
Дижитал дэлгэцтэй
Pulse –ээр гагнах болон цэвэрлэх дэлгэцтэй
Гагнуурын төгсгөлийг автоматаар хийгчтэй
Хөнгөн цагаан болон хөнгөнцагааны хайлш, ган, цэвэрдэггүй ган, зэс зэргийг гагнах боломжтой байх
TIG-200 ACDC маркын аппараттай дүйцэхүйц байх

ЦАХИЛГААН ГАГНУУРЫН АППАРАТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Гаралтын гүйдэл (А)	20-220
2	Оролтын тэжээл	220В /50 Гц /1 фаз
3	Оролтын чадал (кВА)	9
4	Утасны диаметр (мм)	4
5	Хүчдэл (В)	28
6	Үйлдэл	DC stick,
7	Овор хэмжээ (мм)	380*150*260 ихгүй
9	Жин (кг)	5.45
10	Тасралтгүй ажиллах хугацаа	60%

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Зөөврийн зориулалттай байх, дагалдах хэрэгслийн хамт /гар, Ф-25мм ² кабель-30м/
3 pcb платтай байх
Инвертер технологитой
Нумын асалт түргэн, наалдахгүй
Дижитал дэлгэцтэй
Цахилгаан гагнуур болон LiftTig хийх боломжтой
Хэт халалт болон, өндөр гүйдлийн хамгаалалттай

ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Ажлын хүчдэл (кВ)	0.24
2	Хэвийн хүчдэл (кВ)	0.22
3	Давтамж (Гц)	50
4	Гадна орчны температур (°С)	-40.....+40
5	Асаалтын систем	Статор болон гараар
6	Хэвийн чадал (кВт)	5.5-аас багагүй
7	Хамгийн их чадал (кВт)	7.5-аас хэтрэхгүй
8	Түлш	Бензин
9	АҮК	0.8-аас багагүй
10	Госны мэдрэгч	Байх шаардлагатай
11	Хэмжүүр	Олон үйлдэлт функцтэй
12	Гаралтын автомат	25 А
13	Тээвэрлэх боломж	Зөөврийн, тэргэнцэр бүхий
14	Үйлдвэрлэсэн огноо	2018 оноос хойш
15	Хүчдэл тогтворжуулагч	Байх шаардлагатай

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ажлын [санал болгож буй нийлүүлэх хугацааг бичнэ] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Техникийн тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|-----------------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Нийлүүлэхээр санал болгож буй материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо үйлдвэрийн хэсэг БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 (нэг) жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор барагдуулна. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1 Нийлүүлэхээр санал болгож буй материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна.

 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 1. Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

 2. Баталгаат засвар (ГЕН-5)
 - a. Баталгаат засварын тусгай шаардлага.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

 4. Төлбөр (ГЕН – 7)

Урдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний төлбөрийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичиг, нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн санхүүжилтийг төлнө.

.

 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
 - a. Алданги оногдуулах хувь: **Нэг өдрийн 0,5%**
Алдангийн нийт дүн: **Гэрээний нийт үнийн дүнгийн 10%**
-